

Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах
бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн тухай” Засгийн газрын гишүүн, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгын танилцуулга, холбогдох баримт материалтай ажлын журмаар танилцаад ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газарт:

1. Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д шинээр барихаар заасан төмөр замын суурь бүтцийн концессыг төрийн өмчит, эсхүл төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдэд Концессын тухай хуулийн 17.1.1-д заасан журмын дагуу олгох;

2. Шинээр барих төмөр замын техник-эдийн засгийн үндэслэлийг холбогдох тооцоо, судалгааны хамт 2011 оны 08 дугаар сард багтаан боловсруулж дуусгах;

3. Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.2-т заасан эхний үе шатны төмөр замын суурь бүтцийг мөн бодлогын 3.2.4-т заасан 2 дахь үе шатны төмөр замын суурь бүтцийн хамт 2013 онд багтаан ашиглалтад оруулах;

4. Дээрх бодлогын баримт бичгийн 3.2.6-д заасан гуравдугаар үе шатанд барьж эхлэх 3600 орчим км төмөр замын замнал (маршрут)-ыг нарийвчлан тодорхойлж Улсын Их Хуралд танилцуулах.

Хоёр. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргад:

1. Энэхүү зөвлөмжийн дагуу үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтанд чиглэл өгч, биелэлтэд хяналт тавих.